



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2004 оны 9 сарын 20 өдөр

Дугаар 326

Улаанбаатар, 2004

Гадаадад суралцуулах тухай

2004-2005 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2004 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн болон мөн оны 7 дугаар сарын 15-ны өдрийн хурлын тэмдэглэлүүд; Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2.6-г үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дагвадорж овогтой Амарбатыг Шинэ Зеланд улсын Массей Их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр, Эрдэнэбилэг овогтой Ариунтуяаг АНУ-ын Де Врай Их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус 2 жилийн хугацаагаар 2004-2005 оны хичээлийн жилээс суралцуулсугай.

2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2004 оны 9 дүгээр сарын 20-ний өдрийн 320 дугаар тушаал болон мөн оны 7 дугаар сарын 20-ний өдрийн 240 дугаар тушаалын Э.Ариунтуяатай холбогдолтой хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2004.3.10 тушаалд кодификаци хийгдээ.

2004.3.16 тушаалд кодификаци хийгдээ.



САЙД

(Handwritten signature)

А.ЦАНЖИД